



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/684

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.1а, 29.1.2, 29.1.4, 29.1.5в заалт болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/107 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажилд хяналт, үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд: Ц.Цогтбаяр	- Жаргалант сумын Засаг дарга
Г.Гончигсүрэн	- Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны дарга
А. Цэен-Ойдов	- Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
Э.Удвал	- Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн Аймгийн төсөл хэрэгжүүлэх багийн ажилтан
Г.Тунгалаг	- Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн
Б.Эрдэнэцэцэг	- Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч
Х.Мөнхжаргал	- Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч
Ш. Жавзанпагма	- Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны лабораторийн эрхлэгч
М.Нансалмаа	- Шим-Ус орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер

2.

Нарийн бичгийн  
дарга: Ч.Мөнгөнхүү - Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур  
амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн  
Аймгийн төсөл хэрэгжүүлэх багийн ажилтан

2. Хяналт үнэлгээний ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулж,  
тайланг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Энэхүү ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг захиалагчийн  
хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ